

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии



РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей



МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

V

Международная конференция
при поддержке Президента Монголии



19-21 апреля 2021 г. Санкт-Петербург

Сборник докладов

Санкт-Петербург- Улан-Батор
2023

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Ответственный редактор: Академик С. Чулуун
Редакторы-составители: доктор филол. наук И.В.Кульганек
доктор (Ph.D) Н.Хишигт
кандидат филол. наук Д.А.Носов

Культурное наследие монголов: Рукописные и архивные собрания. Сборник докладов V международной научной конференции. 19-21 апреля 2021 г. Санкт-Петербург, Россия. СПб.-УБ., 2023 г. -...с.,

Сборник представляет собой собрание докладов V международной научной конференции "Культурное наследие монголов: рукописные и архивные собрания", организованной Институтом восточных рукописей РАН, Институтом истории и этнологии МАН и Международной Ассоциацией монголоведов в г. Санкт-Петербург, 19-21 апреля 2021 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Институт восточных рукописей РАН, 2023 г

© Институт истории и этнологии МАН, 2023 г.

© Международная ассоциация монголоведов, 2023 г

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн



ОХУ-ЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн



ОЛОН УЛСЫН МОНГОЛ
СУДЛАЛЫН ХОЛБОО



МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

V

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2021 оны 4 сарын 19-21
Санкт-Петербург хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург- Улаанбаатар
2023

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Хариуцлагатай редактор: Академич С.Чулуун
Эмхтгэгч-редактор: Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек
Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт
Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Д.А.Носов

Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга - V. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2021 оны 4 дүгээр сарын 19-21. ОХУ, Санкт-Петербург хот. Санкт-Петербург-Улаанбаатар., 2023 г. ... тал.

Тус эмхэтгэлийг Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбооноос 2021 оны 4 дүгээр сарын 19-21-нд ОХУ-ын Санкт-Петербург хотноо хамтран зохион байгуулсан “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 5 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, угсаатны зүй, улс төр, соёлд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2023 г

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2023 г

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2023 г

MONGOLIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of History and
Ethnology



RUSSIAN ACADEMY OF
SCIENCES
Institute of Oriental
Manuscripts



INTERNATIONAL
ASSOCIATION FOR
MONGOL STUDIES



CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

V

**International Conference
Under the Patronage of the President of Mongolia**



April 19-21, 2021. St. Petersburg

Proceedings

St. Petersburg - Ulaanbaatar
2023

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Edited and compiled by

acad. S.Chuluun
D.Sc.(Philology) I.V.Kulganek,
Ph.D (History) N.Khishigt,
Cand.Sc.(Philology) D.A.Nosov

Cultural heritage of the Mongolis: manuscripts and archival collections. Papers of the V International Conference, April 19-21, 2021. St.Petersburg. St.Petersburg -Ulaanbaatar 2023, pages.

This is a collection of papers, presented at the Fifth International Conference organized by the the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in St. Petersburg on April 19-21, 2021.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Institute of Oriental Manuscripts RAS, 2023 r

© Institute of History and Ethnology MAS, 2023 r.

© International Association for Mongol Studies, 2023 r

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ /

ӨМНӨХ ҮГ / ПРИВЕТСТВИЕ

Приветствие директора Института восточных рукописей РАН, член-корреспондента РАН И.Ф.Поповой	11
Монгол улсын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д. Рэгдэлийн мэндчилгээ	13
Приветствие генерального секретаря международной ассоциации монголоведов, академика С.Чулууна	15
Монгол улсын Их хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн мэндчилгээ	
Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарын мэндчилгээ	

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

Г. Алтансүх.

Аноним Шибани Нāме дахь монгол хүний нэрийн зарим асуудалд

Э. Баярчимэг

Лхаарамба Агваандандарын найруулсан “Сарны гэгээн гэрэл” хэмээх дохионы бичгийн нэгэн хувилбарын тухай

К. И. Бикмаева

Национальные программы по монгольской письменности (монгол бичгийн үндэсний хөтөлбөр) как один из основных документов в области языковой политики монголии

Л. Ганбат

Ибн Арабшах-ийн “Acāibu’l makdūr” зохиолд нүүдэлчдийн байлдах арга, бодлогын тухайд өгүүлсэн нь

Л. С. Дампилова

Жанровое разнообразие архивных материалов Монгольской экспедиции 1967 года

И. М. Захарова, М. В. Мандрик

Экспедиции М.Д. и Н.Д. Бутиных 1870 и 1881 гг. в Китай

И. В. Кульганек, Н. В. Захарова

Фотографии о монголии и монголах в Институте восточных рукописей РАН

Э. Мөнхцэцэг

Монгол улсын Үндэсний Номын сан дахь нэгэн монгол-манж толь бичгийн тухай

Б. Нацагдорж, О. Оюунжаргал

“Хүрээний хэргийн зүй (庫倫事宜)” хэмээх сурвалжийн тухай

Д. А. Носов

Россыпи документов В. А. Казакевича: полевой дневник 1925 г.

Р. Ю. Почекаев

Правовые воззрения монголов в пословицах и поговорках

Э. Пүрэвжав

Хэлмэгдсэн бүтээлүүд: 1938 оны V сарын 12-ны өдрийн акт бичиг

Т. Д. Скрынникова

Сакральность правителя и его ритуальные функции
(По материалам анонимной Altan tobci)

М. В. Федорова

Этнографическая коллекция Д.Э. Ухтомского, привезенная из
экспедиции в Северную Монголию (1910 г.)

А. Д. Цендина

Гадания на кубиках (по материалам квартиры-музея
Ц.Дамдинсурэна и коллекции Р.Отгонбаатара)

Б.-Х. Б. Цыбикова

Локальные особенности устных нарративов бурят о Шоно баторе

С. Чулуун, Н. Хатанбаатар

Берестяная грамота, обнаруженная из раскопок монастыря в
Монгольском гоби

Т. И. Юсупова

Монгольский ученый комитет в отзывах российских исследователей

РЕЗОЛЮЦИЯ

СВЕДЕНИЯ ОБ АВТОРАХ

ЗОХИОГЧДЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

DOI10.48612/IVRRAN/8ng6-d6n6-ehgm

Э. Пүрэвжав

**ХЭЛМЭГДСЭН БҮТЭЭЛҮҮД:
1938 ОНЫ V САРЫН 12-НЫ ӨДРИЙН АКТ БИЧИГ**

Монгол улсын Судар бичгийн хүрээлэн үүсэн байгуулагдаад 100 жил болж байна. Монгол улсын Шинжлэх ухааны хүрээлэнгийн судлаачдын зохиож нийтлүүлсэн, гадаад хэлнээс орчуулсан зарим бүтээлүүдийг улс төрийн талаар шалган хянаж, хүчингүй болгох тухай “Акт бичиг” хэмээх арван зүйл бүхий баримт бичгийг 1938 оны V сард гаргасан нь Монгол улсын Үндэсний төв архивын сан хөмрөгийн Х.23, д.1, хн.449, т.14-19 дугаарт хадгалагдаж байна. Энэхүү хүчингүй болгох тухай “Акт бичиг”-ийн жагсаалтад “Алтан товч”-ийн хоёр боть (1937), “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” сэтгүүлийн 1, 4, 5, 6, 7, 8 дугаар дэвтэр (1934-1935), “Шинэ толь” сэтгүүлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар дэвтэр (1935-1937), Ж.Цэвээний “Дархад, Хөвсгөл нуурын урианхай, дөрвөд, хотон, баяд, өөлд, мянгад, захчин, торгууд, хошууд, цахар, дарьганга, Алтайн урианхай, хасаг, хамниган нарын гарал үндэс байдлын өгүүлэл” (1934), Б.Буянчуулганы “Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлэх хэрэглэгдэхүүн” (1936), Б.Доржийн “Малчнаа сануулах сэдэв” (1936), Я.Цэвэлийн “11 [1921] оноос хойших хэвлэл зүйлийн бүртгэл” (1936), Б.Шагжийн “Үсгийн дүрмийн толь бичиг” (1937), Я.Цэвэлийн “Азийн ангид бүхий бичмэл ба дармал ном бичгийн бүртгэл” (1937) зэрэг бүтээл орсон байдаг. Эдгээр ном, сэтгүүл нь эдүгээ олодохуйяа ховордсон бүтээлийн тоонд ордгийг зориуд тэмдэглэе.

Түлхүүр үг: Монгол, монгол судлал, хэлмэгдсэн бүтээл, 1938.

E. Purevjav

SCIENTIFIC WORKS TO BE DESTROYED: ACT OF MAY 12, 1938

This year marks the 100th anniversary of the Literary Committee of Mongolia. In May 1938, a ten-point document named “Act letter” was issued to review and invalid certain works translated from foreign languages, written and published by researchers of the Mongolian Committee of Sciences. This document is currently stored in the National Central Archives of Mongolia, (X.23, д.1, хн.449, т.14-19). This list of documents includes the two volumes of “Golden History” [Altan tobči] (1937), the 1st, 4th, 5th, 6th, 7th, and 8th

volumes of the “Articles on the Improvement of Mongolian Language Policy” magazine (1934-1935), “New Mirror” [Shine toli] magazine No. 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 (1935-1937), “Book on the Origin of the Darkhad, Uriankhai of Khuvsgul Lake, Dörved, Khoton, Bayad, Ögeled, Mingad, Zakhchin, Torguud, Khosuud, Tsakhar, Dariganga, Uriankhai of Altai, Khasag, and Khamnigan” (1934) by J.Tseveen, “Materials Used to Represent the Period of Conquest of Mongolia from Manchuria” (1936) by B.Buyanchuulgan, “Theme to Remind Herder” (1936) by B.Dorj, “Record of Printed Matter from the Eleventh Year of Mongolia Until Now” (1936) by Ya.Tsevel, “Dictionary of Mongolian Orphography” (1937) by B.Shagj, “Bibliography of Mongolian Books and Manuscripts in the Asian Section of the Mongolian State Library” (1937) by Ya.Tsevel. It should be noted that those books and magazines such as are now among the rare works.

Keywords: Mongolia, Mongol Studies, to be Destroyed, 1938.

Монгол улсын Судар бичгийн хүрээлэн үүсэн байгуулагдаад 100 жил болж байна. Монгол улсын Шинжлэх ухааны хүрээлэнгийн судлаачдын зохиож нийтлүүлсэн, гадаад хэлнээс орчуулсан зарим бүтээлүүдийг улс төрийн талаар шалган хянаж, хүчингүй болгох тухай “Акт бичиг” хэмээх арван зүйл бүхий баримт бичгийг 1938 оны V сард гаргасан нь Монгол улсын Үндэсний төв архивын сан хөмрөгийн X.23, д.1, хн.449, т.14-19 дугаарт хадгалагдаж байна.



Шинжлэх Ухааны Хүрээлэнгээс зохиож нийтлүүлсэн болон орчуулсан бүтээлүүдийг улс төрийн талаар шалган хянаж, хүчингүй болгох тухай акт бичгийн 1-р нүүр

Энэхүү “Акт бичиг”-ийн гар бичмэл эхийн 6 нүүр бүхий хуулбарыг нь 2020 онд Монгол улсын Үндэсний номын сангийн 100 жилийн түүхэн ойд зориулан нийтлүүлсэн “Монгол улсын Үндэсний номын сангийн баримтын эмхэтгэл”, I боть (1921-1971) хэмээх түүвэр бүтээл [Монгол улс 2020: 282-287]-д анх удаа нийтлүүлж, өргөн олны хүртээл болгожээ. Энэхүү акт бичгийн гар бичмэлийн бүрэн эхийг сийрүүлбэл:

Нэгдүгээр зүйл: Бидний биес Шинжлэх ухааны хүрээлэнгийн даргын тушаалаар тус хүрээлэнгээс эрхлэн 22 [1932] оноос эдүгээ хүртэл хэвлэн нийтэлсэн бүхий л хэвлэлийн дотроос зохих газрын шийдвэрийн ёсоор гадаадаас орчуулсан зүйлүүд ба жинхэнэ тушаал тогтоолын чанар бүхий хэвлэлийг хасаж, чухам улс төрийн талаар шалган хянаваас зохих хэвлэлүүдийг бүртгэн үзвээс, бүгд 28 дэвтэр болох бөгөөд нэрсийг жагсааваас:

1. “Алтан товч”-ийн тэргүүн, дэд¹
2. “[Монгол] хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” 1, 4, 5, 6, 7, 8 дугаар дэвтэр²
3. “11 [1921] оноос хойших хэвлэл зүйлийн бүртгэл”
4. “Азийн ангид бүхий бичмэл ба дармал ном бичгийн бүртгэл”
5. “Шинэ толь” хэмээх сэтгүүл 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар дэвтэр
6. “Манжаас Монголыг эзэрхсэн үеийн хэрэглэгдэхүүн”³
7. “Бага ястны гарал үндэс”⁴

¹ “Алтан товч”-ийн оршилд “Тус Шинжлэх ухааны хүрээлэнгээс энэ нэрт бичгийг хэвлэн тархаасны уг санаа болбоос, өөрийн эх орны хуучин түүхийг судлагчид ба үндэсний олон эрдэмтэн оюутан нарын унших судлахууд хэрэглэгдэхүүн болоосой хэмээсэн нь буюу” гэж бичсэн байдаг.

² “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” хэмээх монгол хэл бичгийн судлал, түүний хэтийн ирээдүйн хөгжилд чухал ач холбогдолтой эрдэм шинжилгээний анхны сэтгүүл 9 дугаар хэвлэгджээ.

³ Бүрэдийн Буянчуулган (1885-1937) “Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлэх хэрэглэгдэхүүн” гэдэг бүтээлийг 1936 онд бичиж туурвижээ.

⁴ Ж.Цэвээн. Дархад, Хөвсгөл нуурын урианхай, дөрвөд, хотон, баяд, өөлд, мянгад, захчин, торгууд, хошууд, сахар, дарьганга, Алтайн урианхай, хасаг, хамниган нарын гарал үндэс байдлын өгүүлэл. УБ., 1934. 147 х.

Профессор Ж.Цэвээний туурвисан энэхүү судалгааны ганц сэдэвт бүтээлийн 1-9 дүгээр талд “Дархад ба Хөвсгөл нуурын урианхай”, 9-33 дугаар талд “Ард хүмүүсийн тухай”, 34-61 дүгээр талд “Дөрвөд”, 62-70 дугаар талд “Хотон”, 71-74 дүгээр талд “Баяд”, 75-81 дүгээр талд “Өөлд”, 82-84 дүгээр талд “Мянгад”, 85-89 дүгээр талд “Захчин ба торгууд хийгээд хошууд”, 90-92 дугаар талд “Торгууд”, 93-98 дугаар талд “Сахар”, 99-110 дугаар талд “Дарьганга”, 111-128 дугаар талд “Алтайн урианхайн байдал”, 129-133 дугаар талд “Хасаг”, 134-145 дугаар талд “Хамниган” гэж угсаатны бүлэг хуваан тун дэлгэрэнгүй өгүүлжээ. Угсаатан болгоны аж байдлын ерөнхий онцлог, амьдран суудаг нутаг орон, тухайн газар нутгийн байгалийн баялгийн

8. “Үсгийн дүрмийн толь бичиг”⁵
9. “Тооны ухааны нэр томъёо”
10. “Бодисын зүйн нэр томъёо”
11. “Хувилахуй ухааны нэр томъёоны бичиг”
12. “Малчны сургаал”⁶
13. “Аж ахуйн тэмдэглэл”⁷
14. “Малчнаа сануулах сэдэв”⁸ эдгээр болжухуй.

Хоёрдугаар зүйл: Эл хянан шалгагдах хэвлэлүүдийн дотроос “Алтан товч”-ийн тэргүүн, дэд, “Хэвлэл зүйлийн бүртгэл”, “Азийн ангийн бичмэл ба дармал ном бичгийн бүртгэл”, “[Монгол] хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл”-ийн I, IV, V, VII дугаар, “Манжаас Монголыг эзэрхсэн үеийн хэрэглэгдэхүүн” эдгээр ангийн бичиг зохиол болбоос цаашид манай улс ардад хэрэглэж болох эрдэм шинжилгээний буюу түүх, утга зохиолын холбогдол бүхий бичгүүд болох тул хэвээр үлдээсүгэй.

Гуравдугаар зүйл: Энэ завсар хэвлэгдэн тархагдсан ба тархаж бүхий бичиг зохиолуудын дотор хувьсгалын эсэргүү нарын хор нөлөөгөөр дутагдалтай болсон буюу мөн ч бага сага үл бүтэх зүйл шурган орсон зохиолууд нэлээд баймуй. Нэрлэвээс: “Тооны нэр томъёоны бичиг”, “Цаг уур, газар зүйн нэр томъёоны бичиг”, “Бодисын зүйн нэр томъёоны бичиг”, “Хувилахуй ухааны нэр томъёоны бичиг” эдгээр болмуй. Гэвч эдний зууны ная, ерэн хувь нь бидний цаашдын ажил дээр хэрэглэж болох тустай зүйлүүд болох тул, цөөн тооны зохилдохгүй зүйлүүдээр шалтгаалж гол болох тустай зүйлүүдийг хүчингүй болговоос болохгүй баймуй”. Жишээлбээс: “Тооны ухааны орос монгол нэр томъёоны бичиг” дотор “*шүшүм*” хэмээвээс зохихыг “*kimšay-a*” хэмээсэн зэрэг хэдэн арван үл зохих нэр томъёо байвч, олонх нь хэрэгтэй зүйлүүд

талаар баримт нотолгоо сайтай бичсэн байна. Жишээлбэл: Уул ганц сэдэвт бүтээлд “Дархадын Шишгид голын загас болбоос их сайн. Бас хүдэр, хэрэм, булганы агнуур бага зэрэг хийж болох. Алсдаа уул уурхайн зүйл: зэс, бал, алт, тугалга мэтийг нээж болох магадгүй” хэмээн бичсэн байдаг нь эдүгээгийн Эрдэнэтийн их бүтээн байгуулалтыг зөн совингоороо хэлсэн хэрэг буй за.

⁵ Садоо овогт Б.Шагж (1886-1937) гэлэн 1937 онд зохиож хэвлүүлсэн “Монгол үсгийн дүрмийн толь бичиг”. Энэ толийн өмнөх үг, төгсгөлийн үгийг урж, зохиогчийн нэрийг хусаж арилгаж байжээ.

⁶ Тогтохтөр (1797-1887) вангийн бичиж туурвисан “Малчны сургаал”.

⁷ Бүрээдийн Буянчуулган (1885-1937) “Цахарын мал аж ахуй” хэмээх бүтээлийг 1936 онд хэвлүүлжээ.

⁸ Боржигин овогт Буньбазарын Дорж (1878-1943) 1936 онд нийтлүүлсэн “Малчнаа сануулах сэдэв”.

болох тул хүчингүй болговоос болохгүй нь илэрхий баймуй. Эл учраас дээр нэр дурдсан 4 ангийн бичиг зохиолыг хүчинтэй хэвээр үлдээж, бага сага засах залруулах өөрчлөх зүйлүүдийг ШУХ-ийн Дуун ухааны тасгаас нэн даруй залруулан гүйцэтгэхийг даалгаваас зохимуй.

Дөрөвдүгээр зүйл: “Шинэ толь” сэтгүүлд бичсэн өдий төдий зүйлүүдийн дотор хувьсгалын эсэргүү нарын гарын үсэг зурж орчуулсан, зохиосон зүйлүүд нэлээд олон баймуй. Үүнд орчуулсан буюу орчуулсан боловч өөрийн зохиол мэтээр үзэж гарын үсэг зурсан шинжлэхүй ухааны зүйлүүд бас буй. Эл зүйлийн ашиг тус бүхий орчуулга ба хулгайлан үсэг зурсан түүвэр орчуулгыг хувьсгалын эсэргүү нарын нэр халдсан төдийгөөр хамт хүчингүй болговоос зүйд хараахан нийлэлцэхгүй тул зохих газрын шийдвэрийн ёсоор хүчинтэй хэвээр үлдээж, жинхэнэ эсэргүү нарын өөрийн санаа бодлоор бичсэн зүйлүүдийг ялган, зохиосон хүний нэр, “Шинэ толь” сэтгүүлийн хэддүгээрт ямар гарчигтай хэвлэгдсэн болохыг тусгай хүснэгт тодорхойлж, тус бүрийн доор хүчингүй болгох тухайн саналыг хавсаргав.

Тавдугаар зүйл: Шинжлэх ухааны хүрээлэнгийн бүхий л хэвлэлийн дотор энэ актаар хүчинтэй хэвээр үлдээсэн зүйлүүдийн дотор зохиогч буюу орчуулагч хийгээд сэтгүүлийн эрхлэгчийн хувиар нэр дурдсан хувьсгалын эсэргүү нар болох Дэמיד, Ринчен⁹, Буянчуулган¹⁰, Цэвээн¹¹,

⁹ Еншөөбү овогт Бямбын Ринчен (1905-1977). Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн захиалгаар 1924-1927 онд Ленинград хотын Дорно дахины хэлний хүрээлэнд тусгай хөтөлбөрөөр суралцаж, 1927 оны III сараас Дуун ухааны тасгийн ажилтан болж 50 жил ажиллажээ. 1956 онд Унгарт “Монгол бичгийн хэлний зүй” бүтээлээрээ хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг хамгаалж, 1945 онд Монгол улсын Төрийн шагнал, 1956 онд профессор, 1961 онд ШУА-ийн жинхэнэ гишүүнээр сонгогджээ. Академич Б.Ринчен “Орчуулгын чанарыг дээшлүүлэх тухай” (1934), 3 боть “Les Matériaux pour L'étude du Chamanisme Mongol” (1959-1975), 5 боть “Folklore Mongol” (1960-1972), 4 боть “Монгол бичгийн хэлний зүй” (1964-1967), “Монгол нутаг дахь хадны бичээс, гэрэлт хөшөөний зүйл” (1968), “Монгол ард улсын хамниган аялгуу” (1969) тэргүүтэн судалгааны бүтээл хэвлүүлжээ.

¹⁰ Бүрэдийн Буянчуулган (1885-1937). Цахарын Шулуун шар хошууны Ар булаг хэмээх газарт төрж, 1925-1929 онд БНМАУ-аас ЗХУ-д суух бүрэн эрх барих элчин төлөөлөгчөөр ажиллажээ. Тэрбээр “Монголын бүх газар нутаг” (1932), “Монгол, Дундад олон улсын товч түүх” (1933), “Манж, Монголын холбогдсон түүхт байдал” (1934), “Монгол өөлдийн түүх” (1935), “Монголын эрт эдүгээгийн газар тариалангийн түүх” (1935), “Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлэх хэрэглэгдэхүүн” (1936), “Цахарын мал аж ахуй” (1936) тэргүүтэн бүтээл бичиж туурвижээ.

¹¹ Шарайд овогт Жамсрангийн Цэвээн (1881-1942). 1897 онд Санкт-Петербургийн гимнази, 1901 онд Эрхүүгийн багшийн сургуулийг дүүргэжээ. Ж.Цэвээн 1921 онд Судар бичгийн хүрээлэнгийн 15 зүйлтэй дүрэм, 1924 онд “Судар бичгийн эрхлэх үйлдвэрийн товчоо” боловсруулахад идэвхтэй оролцож, Судар бичгийн хүрээлэнгийн

Пэрэнлэй, Шагж¹², Цээнрэгжил, Ширнэн, Гонжоон, Дашчирав, Аюуш, Буяннэмэх, Дашням, Санжаажамц, Баттөмөр¹³, Дамдин, Пунцаг, Магсар, Хөхдэй, Дугаржав нарын нэрийг бүрэн хүчингүй болгосугай.

Зургаадугаар зүйл: То вангийн “Малчны сургаал”, Доржийн зохиосон “Малчнаа сануулах сэдэв”¹⁴, эсэргүү Буянчуулганы эмхэтгэсэн “Цахарын

Эрдэмтэн нарийн бичгийн даргын албыг 1921-1931 онд хашжээ. ЗХУ-ын ШУА-ийн шийдвэрээр 1935 оны 10 сарын 25-ны өдөр хэл бичгийн ухааны докторын зэрэг олгожээ. “Образцы монгольской народной литературы” (1908), “Суут богд Чингис хааны Алтан сургаал” (1915), “Улсын эрх” (1924), “Монголын дархан сүлд цаазтай газруудын учир” (1925), “Орчлон ертөнцийн байдал” (1926), “Монгол улсын эрдэм шинжилгээний ажлын ач холбогдол” (1930), “Дархад, Хөвсгөл нуурын урианхай, дөрвөд, хотон, баяд, өөлд, мянгад, захчин, торгууд, хошууд, цахар, дарьганга, Алтайн урианхай, хасаг, хамниган нарын гарал үндэс байдлын өгүүлэл” (1934), “Монгольские летописи XVII века” (1936) тэргүүтэн судалгааны бүтээл туурвижээ.

¹² Садоо овогт Баясгалангийн Шагж ”(1886-1938).1923 онд Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн судрын сан хадгалагч, 1924 онд төвөд хэлний орчуулагч, 1925 онд Судар бичгийн хүрээлэнгийн сул гишүүнээр сонгогдож, 1925 онд ЗХУ-ын ШУА-ийн 200 жилийн ойн баярт профессор Ж.Цэвээний хамт уригдан оролцжээ. Тэрбээр “Эрдэнэ мэт үсгийг хялбар эвлүүлж, чимэг болгон хэрэглүүлэх Амар хөтөлбөр” (1927), “Эрэхүйе хялбар болгон зохиосон монгол үгийн тайлбар Чандманийн эрих” (1929), “Үсгийн дүрмийн товч толь бичиг” (1933), “Монгол бичгийн дөт зам” (1934), “Монгол үсгийн дүрмийн толь бичиг” (1937) тэргүүтэн бүтээл бичиж туурвижээ.

¹³ Цэндийн Баттөмөр Монгол улсын Гэгээрлийн яамны сайдын албан тушаалд анхлан 1932 оны 7 сарын 4-нөөс 1934 оны 4 сарын 27-ны өдөр хүртэл, дараа нь Гэгээрүүлэх яамны сайдын албан тушаалд 1936 оны 7 сарын 31-ний өдрөөс 1937 оны 9 сарын 10-ны өдөр хүртэл дахин ажиллаж байжээ. Ц.Баттөмөр нь монгол үндэсний утга соёл, монгол хэл бичгийн судлалын чиглэлээр “Ардын төв театрын ажил явдал бол манай нэгэн чухал үүрэг мөн” (1932), “Хуучин монгол үсгээс латин үсэгт орох тухай бодлого” (1932), “БНМАУ-ын Ардыг гэгээрүүлэх яамнаас төв ба орон нутгийн газруудад үндэсний дуу хөгжмийн дугуйланг хэрхэн байгуулах тухай гаргасан заавар” (1934), “Улсын дээд эрхийг барих Улсын XVIII бага хурлаас өргөн ардыг үндэсний бичиг үсэгт сургах ажил бол манай ойрын үед гүйцэтгэх зүйлийн нэгэн чухал нь мөн хэмээн тогтоосон баймуй” (1934), “Өргөн ардыг үндэсний бичиг үсэгт сургах ажлын тухай” (1934), “Үндэсний бичиг үсэг бол үндэсний хувьсгалт соёл боловсролын түлхүүр нь мөн” (1936), “Ардын аман зохиолыг цуглуулах явдалд өргөнөөр оролцогтун” (1936), “Бичиг үсэг мэдэхгүй албан хаагчид ба ажилчдыг албан журмаар сургах хэмээсэн бодлогыг биелүүлэгтүн” (1936) тэргүүтэн нийтлэл, өгүүлэл бичжээ.

¹⁴ Монгол улсын Сангийн яамны сайд, Шинжлэх ухааны хүрээлэнгийн жинхэнэ гишүүн, Хэл бичгийн кабинетын ажилтан, ахмад сурган хүмүүжүүлэгч, аман өгүүлэгийн их мастер, зохиолч Боржигин овогт Буньбазарын Дорж (1878-1943). “Өөлд мэйрэн” хэмээн өргөн олонд алдаршжээ. 1924 онд Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн Нэр томьёоны их комиссын Урлахуй ухааны ажлын хэсэгт оруулжээ. Монгол улсын Шинжлэх ухааны хүрээлэнгийн товчооны гишүүдийн хурлаас 1933 онд шинэчлэн томилсон “Тайлбар толийн комисс”-ын долоон гишүүний нэг нь Дорж мэйрэн байсан юм. Тэрбээр “Remington” бичгийн машины үйлдвэрт захиалах бичгийн машины монгол үсгийн тигийг цохилуурт нь тохируулан зохиож, “Монгол хэлний

мал аж ахуйн тэмдэглэл” хэмээх гурван зүйлийг тус Шинжлэх ухааны хүрээлэнгийн Хөдөө аж ахуйн тасгаас ойрын цагт тусгай мэргэжилтэн эрдэмтэнтэй нийлж шалган дүгнэх хэмээж буй тул тэр тухайд аяндаа шалгаран гарах тул одоо хүчинтэй хэвээр үлдээсүгэй. Ганцхүү “Цахарын мал маллагааны тухай түүвэрлэн бичив” хэмээсэн эсэргүү Буянчуулганы нэрийг 5 дахь зүйлд заасан ёсоор хүчингүй болгосугай.

Долоодугаар зүйл: “Хувьсгалын эсэргүү Цэвээн Жамсрангийн эмхэтгэв” хэмээсэн “Бага ястны уг гарлын бичиг”, “Шагжийн хураамжлав” хэмээсэн “Монгол үсгийн дүрмийн толь”¹⁵ энэ хоёр бичиг болбоос, хэдийгээр эсэргүү этгээд нарын гараар түүвэрлүүлэн эмхэтгүүлсэн боловч, уг зохиолууд уулаас тэдний санаа бодлогоор хорлох үүргийн дотор бүтээгдсэн бичгүүд бус [Шинжлэх ухааны] хүрээлэнгээс тушааж хийлгээд, хянаж хэвлүүлсэн зүйлүүд болмуй. Гэвч тэдний шургуулан оруулсан бага сага үл бүтэх зүйлүүд буй. Үүнийг шүүрдэн арилгаж цэвэр болгохыг Дуун ухаан ба Түүхийн тасагт даалгаж, ерөнхийд [нь] хүчинтэй хэвээр үлдээсүгэй.

Наймдугаар зүйл: Энэ завсраа хэвлэгдсэн бүхий л хэвлэлийн дотор өмнөх 5 дугаарт дурдсан хувьсгалын эсэргүү нарын нэрээр бичсэн буюу тэдний нэрийг оролцуулан бичсэн оршлуудыг нэгэн адил хүчингүй болгосугай.

Есдүгээр зүйл: “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын бичиг [өгүүлэл]”-ийн гуравдугаарт гарсан хувьсгалын эсэргүү Ринчений шүүмжлэл, мөн хоёрдугаарт гарсан хувьсгалын эсэргүү Мэргэн гүн Гомбожавын шүүмжлэл¹⁶ энэ хоёр болбоос хоёр нүүрийн аргаар хуурамч

тайлбар толийн комисс”-ын гишүүнээр ажиллаж, “Малчнаа сануулах сэдэв” хэмээх судалгааны бүтээлээ 1936 онд хэвлүүлж, “Заяатын шунал, Зүтгэлтийн бодол”, “Эртэй уургач Эрэндоо” хэмээх шүлэг, “Туулай, төлөг, чоно гурвын үлгэр” зэрэг зохиол бичиж нийтлүүлсэн байна.

¹⁵ Садоо овогт Баясгалангийн Шагж 1937 онд 27000 үгтэй “Монгол үсгийн дүрмийн толь бичиг”-ийг эмхэтгэн найруулжээ. Тэрбээр уг толь бичгийнхээ төгсгөлийн үгэнд “Манай Монголын улс төр ба шинжлэх ухаан улмаар хөгжин дэлгэрч бүхий энэ үед үгийн баялаг ба үсгийн дүрэм чухал хэрэглэгдэх буй за хэмээснээр бичгийн үг, ардын ярианы үг, шинэ хөгжлийн үгсээс чадахын хэрээр түүвэрлэн бичсэнээр энэхүү 27000 толгой үг бүхий үсгийн дүрмийн толь бичгийг зохион бичив” хэмээн бичсэн байдаг.

¹⁶ Монгол улсын Шинжлэх ухааны хүрээлэнгээс эрхлэн 1934 оны 5 сард хэвлэн гаргасан “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл”-ийн II дэвтэрт М.Гомбожав “Сургуулийн бичиг дэвтрийн чанарыг сайжруулах сэдэв” гэсэн эрдэм шинжилгээний шүүмж өгүүлийг нийтлүүлсэн байдаг. Энэхүү шүүмж өгүүлийн оршилд “Манай монголын нийт соёл боловсролын талаар урагш давшихуй нь эдүгээ олон сургууль лугаа гүнээ холбогдох тул, сургуулийн хэргийг чухал болгон үзэх аж. Сургуулийн хэргийг чухалчлахуйд мөнхүү сургуулийн бичиг дэвтрийг

шүүмжлэл тавьж, хэрэг дээрээ манай улсын шинэ орчуулагчид, шинэ бичигчдийг дайран мохоосон хорт зүйл болох тул хүчингүй болгоё.

Аравдугаар зүйл: “Шинэ толь” сэтгүүлийн 3-4 ба 5-6 дугаарт бүхий хувьсгалын эсэргүү Лувсандорж, Дэмид, Дашчирарав, Мэнд, Яндаг, Элээ нарын зургийг хүчингүй болгон устгасугай.

Үүнээс дээш хүчинтэй үлдээсэн нь бүгд 26, хүчингүй болгосон 2 дэвтэр, сэтгүүлийн дотроос хүчингүй болгосон 14 зүйл, бусдыг хүчинтэйгээр явуулжухуй.

Акталсан Лувсанвандан¹⁷, Жадамба.

Акталсныг баталсан Шинжлэх ухааны хүрээлэнгийн дарга¹⁸ хэмээн тэмдэглэсэн нь буй.

Энэхүү акт бичигт нэр дурдсан, судалгааны ач холбогдол бүхий “Алтан товч”-ийн хоёр боть (1937), “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” сэтгүүлийн 1, 4, 5, 6, 7, 8 дугаар дэвтэр (1934-

эрхэм болговоос зохимуй. Ер сургуулийн бичиг дэвтэр, ялангуяа хэл бичиг сургах дэвтэр болбоос нэгхэн ч үсгийн алдаагүй бөгөөд хэлний дүрэм ба найруулгын талаар өчүүхэн төдий эндэгдэл үгүй, утга маш тодорхой, бас зохиосон нь сурах ба сургахуйд хялбар ахул сая түүнээс тус гармуй. Хэрвээ тийм бус аваас харин хор болохуйд үл болох газаргүй. Үүнд Ардыг гэгээрүүлэх яамнаас тусгайлан сургуульд заах ба заахуйд хэрэглэхээр зохион гаргасан бичиг дэвтрийн тоо цөөнгүйн дээр, эдгээрийн чанарыг нийтэд асар муу хэмээн хэлж хараахан болшгүй тул, сайшаан тэмдэглэсүгэй. Хэдий тийм боловч, эдүгээгийн нэгэнтээ зохиогдон гарсан сургуулийн бичиг дэвтрүүдийг бүрнээ сайн хэмээж үл болох учир, эдгээрийг нарийвчлан шинжилж, түүний сайныг тэмдэглэн, муут илрүүлж, хойчид зохион гаргах сургуулийн бичиг дэвтрүүдийн чанарыг сайжруулахуйд тус нэмэр болговоос зохимуй. Энэ нь Монгол улсын соёл боловсролыг хөгжүүлэхийг хүсэгчдийн үүрэг даруй мөн амуй. Иймийн тул, бид саяхан Ардыг гэгээрүүлэх яамнаас хэвлэн гаргасан “Монгол үсэг. Ишдорж зохиов. 23 (1933 он” хэмээх бүгд 80 хуудас, нэгэн дэвтэр бичгийг үлгэр болгож, товчхоноор шалган үзэцгээе” хэмээн бичсэн байдаг. Герман, Францад суралцаж байсан хүүхдүүдийн ахлагч багш байсан “Монголын Ушинский” хэмээх Б.Ишдоржийн бичсэн монгол хэлний сурах бичигт Францад суралцаж байсан М.Гомбожав шүүмж өгүүлэл бичсэн нь нэн сонирхолтой.

¹⁷ Бэсүд овогт Шадавын Лувсанвандан (1910-1983). Тэрбээр 1936-1943 онд Монгол улсын Шинжлэх ухааны хүрээлэнгийн Дуун ухааны тасгийн эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтан, 1945 онд ШУХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1947-1948 онд Монголын Зохиолчдын хорооны даргаар томилогдож, 1956 онд профессор, 1961 онд ШУА-ийн жинхэнэ гишүүнээр сонгогджээ. Академич Ш.Лувсанвандан “Монгол хэлний зүй” (1939), “Орос, монгол толь” (1942), “Монгол хэл аялгууны учир” (1959), “Орчин цагийн монгол хэл” (1961), “Орчин цагийн монгол хэлний бүтэц” [авиа, авиалбар хоёр нь] (1967), “Орчин цагийн монгол хэлний бүтэц” [монгол хэлний үг, нөхцөл хоёр нь] (1968), “Монгол хэл шинжлэлийн асуудлууд” (1981) тэргүүтэн судалгааны бүтээл бичиж туурвижээ.

¹⁸ Лхамсүрэнгийн Дэндэв (1895-1956) нь Монгол улсын Шинжлэх ухааны хүрээлэнгийн орлогч даргаар 1932-1934 онд, жинхэнэ даргаар 1934-1940 онд ажиллаж байжээ.

1935), “Шинэ толь” сэтгүүл 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар дэвтэр (1935-1937), “Ж.Цэвээн. Дархад, Хөвсгөл нуурын урианхай, дөрвөд, хотон, баяд, өөлд, мянгад, захчин, торгууд, хошууд, сахар, дарьганга, Алтайн урианхай, хасаг, хамниган нарын гарал үндэс байдлын өгүүлэл” (1934), “Б.Буянчуулган. Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлэх хэрэглэгдэхүүн” (1936), “Б.Дорж. Малчнаа сануулах сэдэв” (1936), “Я.Цэвэл. Монгол улсын арван нэгдүгээр оноос эдүгээ хүртэлх хэвлэмэл зүйлийн бүртгэл” (1936), “Я.Цэвэл. Монгол улсын номын сангийн Азийн ангид бүхий монгол ангийн бичмэл ба дармал ном бичгүүдийн бүртгэл” (1937), “Б.Шагж. Монгол үсгийн дүрмийн толь бичиг”(1937) зэрэг ном, сэтгүүл нь эдүгээ олохуйяа ховордсон бүтээлийн тоонд ордгийг зориуд тэмдэглэе.

Монгол улсын Шинжлэх ухааны хүрээлэнгийн Дуун ухааны тасгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Ринчен, мэргэн гүн М.Гомбожав, Ц.Дамдинсүрэн, Б.Содном нар санаа зориг нийлж, монгол “албан бичгийн үг найруулга дэндүү болхийг сайжруулан засах зорилгоор нэгэн цуврал гаргахаар шийдэцгээсэн гэдэг. Ямар нэр өгвөл зохих вэ гэдгийг Дуун ухааны тасгийн тайлбар толийн комиссын гишүүд Ц.Бат-Очир, өөлд Дорж гуай, Б.Шагж гуайн хамт зөвлөлдөн хэлэлцээд, “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” гэж нэрлэвэл зүйтэй гэж өвгөдийн санал гаргасныг зөвшөөрч, Б.Содном хавтасны өнгө хэлбэрийг санаачлан гаргаж, хичээнгүй үсэг бичдэг Ц.Бат-Очир гуай нэрийг нь бичиж, үүсгэн гаргасан” түүхтэй ажээ. “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” цуврал нь 1934 оны 5-р сараас 1935 оны 7-р сард нийтдээ 9 дугаар гарчээ.

I дэвтэрт академич Ц.Дамдинсүрэн “Хичээл билгээ гаргаж, хэл бичгээ хөгжүүлэе”, академич Б.Ринчен “Монгол хэл бичгийг эвдэн гутаахтай тэмцэн тулах цаг ирсэн биш үү”, В.И.Ленин “Орос хэлийг цэвэрлэн ариутгах тухай бичсэн өгүүлэл”,

II дэвтэрт мэргэн гүн М.Гомбожав “Сургуулийн бичиг дэвтрийг сайжруулах сэдэв”,

III дэвтэрт Б.Ринчен “Орчуулгын чанарыг дээшлүүлэх тухай”,

IV дэвтэрт Ц.Бат-Очир “Монгол үсгийн мөрдөн дуурайх үлгэр”,

V дэвтэрт Б.Содном “Утга зохиолын тухай”,

VI дэвтэрт Ж.Цэвээний орчуулсан “Декамерон”,

VII дэвтэрт Манжаас өмнөх үеийн монгол уран зохиолын зүйлээс “Алтан товч”-ийн түүвэр зохиолыг Б.Ринчений хураамжилснаар,

VIII дэвтэрт “Нидерланд улсын бичгийн хүн Мүлтэтүлийн зохиолын зүйл”,

IX дэвтэрт Б.Содномын хураамжилсан аман зохиолоос “Цэцэн үгсийн түүвэр”

зэрэг үндэсний монгол хэл бичиг, хэл ярианы соёлын үндсэн асуудлыг хөндсөн онол болон хэрэглээний ач холбогдолтой сонгодог бүтээлүүд хэвлэгдэн гарч, өргөн олны хүртээл болжээ. “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” цувралын тэргүүн дэвтрийн Оршилд “Орчин үеийн монгол хэлний байдлыг анхааран үзвээс, зохиол найруулга, орчуулга, нэр томъёо зэргийн маш олон зүйлд хянан засаж, шинжлэн залахгүй болбоос, болохгүйд хүрсэн байдал зүйл зүйлээр илтгэгдэн буй тул улс гэрийн соёлыг өрнүүлэн хөгжүүлэхийг эрхэм хүнд болгож буй энэ үеэс хэлний хувьсан улирах жам мөрийг хянан шинжилж, залан удирдах явдал маш чухал болов” хэмээн уул эрдэм шинжилгээний бичгийн хэвлэгдэж гарах болсон учир шалтгааныг тайлбарласан байна. Түүнчлэн зөвхөн өөрийн орны эрдэмтэн судлаачдын бүтээл, уран зохиол, аман зохиолыг хэвлэн нийтлэхээс гадна ард түмнээ дэлхийн соёлтой танилцуулах үүднээс өрнийн алдартай зохиолуудыг орчуулан хүргэхийг чухалчилж байсныг уг цувралын VI, VIII дугаараас мэдэж болно. VI дэвтэрт Италийн сэргэн мандалтын үеийн хүмүүнлэг үзэлтний гол төлөөлөгчдийн нэг Жованни Бокаччогийн “Декамерон” зохиолыг орос хэлнээс дамжуулан Ж.Цэвээн орчуулж “Монгол үгийн зүйд нийлэлцэх сайн орчуулгын байдлыг үзүүлэхийн хамтаар монголын олон уншигч нарт Европ дахины нэрт бичгийн нэгэнтэй товч танилцуулсугай хэмээн нийтлэв” хэмээн оршил бичсэнээс харж болно.

“Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” хэмээх цувралд монгол хэл бичгийн судлалтай шууд холбогдол бүхий нэлээд хэдэн эрдэм шинжилгээний бүтээлийг нийтлэхээр урьдчилан төлөвлөсөн байсан хэдий ч тухайн цаг үеийн нийгэм, улс төрийн ороо бусгаа “зан төрх” [Пүрэвжав 2020. С. 39], хараат байдал, хатуу чанга үзэл сурталтай холбоотойгоор хэвлэгдэлгүй, олны хүртээл бололгүй үлдсэн байна. Тухайлбал: их зохиолч Д.Нацагдоржийн туурвисан “Латин үсгийг сурах дэвтэр”, академич Б.Ринчений бичсэн “Монгол үсгийн эртнээс уламжилсаар ирснийг илтгэх бичиг”, толь зүйч Я.Цэвэлийн зохиосон “Монгол хэлний зүйг илтгэсэн бичиг” зэргийг дурдаж болно. Өөрөөр хэлбэл, энэхүү акт бичиг албажиж гарахаас өмнө “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” цуврал сэтгүүл хэвлэгдэхээ больсон байна.

1938 оны “Акт бичиг”-ийн *есдүгээр зүйлд* “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын бичиг [өгүүлэл]”-ийн гуравдугаарт гарсан хувьсгалын эсэргүү Ринчений шүүмжлэл, мөн хоёрдугаарт гарсан хувьсгалын эсэргүү Мэргэн гүн Гомбожавын шүүмжлэл энэ хоёр болбоос хоёр нүүрийн аргаар хуурамч шүүмжлэл тавьж, хэрэг дээрээ манай улсын шинэ орчуулагчид, шинэ бичигчдийг дайран мохоосон хорт зүйл болох тул хүчингүй болгоё” гэх зэргээр бичиж байжээ. Энэхүү “Акт бичиг”-ийн *хоёрдугаар зүйлд* өгүүлснээр “Эл хянан шалгагдах хэвлэлүүдийн дотроос “Алтан товч”-ийн тэргүүн, дэд, “Хэвлэл зүйлийн бүртгэл”, “Азийн ангийн бичмэл ба дармал ном бичгийн бүртгэл”, “[Монгол] хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл”-ийн I,IV,V,VII дугаар, “Манжаас Монголыг эзэрхсэн үеийн хэрэглэгдэхүүн” эдгээр ангийн бичиг зохиол болбоос, цаашид манай улс ардад хэрэглэж болох эрдэм шинжилгээний буюу түүх, утга зохиолын холбогдол бүхий бичгүүд болох тул хэвээр үлдээсүгэй” гэсэн байдаг бол, “*гуравдугаар зүйлд*, Энэ завсар хэвлэгдэн тархагдсан ба тархаж бүхий бичиг зохиолуудын дотор хувьсгалын эсэргүү нарын хор нөлөөгөөр дутагдалтай болсон буюу мөн ч бага сага үл бүтэх зүйл шурган орсон зохиолууд нэлээд баймуй. Нэрлэвээс: “Тооны нэр томьёоны бичиг”, “Цаг уур, газар зүйн нэр томьёоны бичиг”, “Бодисын зүйн нэр томьёоны бичиг”, “Хувилахуй ухааны нэр томьёоны бичиг” эдгээр болмуй. Гэвч эдний зууны ная, ерэн хувь нь бидний цаашдын ажил дээр хэрэглэж болох тустай зүйлүүд болох тул, цөөн тооны зохилдохгүй зүйлүүдээр шалтгаалж гол болох тустай зүйлүүдийг хүчингүй болговоос болохгүй баймуй”. Жишээлбээс: “Тооны ухааны орос монгол нэр томьёоны бичиг” дотор “*šuyum*” хэмээвээс зохихыг “*kimčay-a*” хэмээсэн зэрэг хэдэн арван үл зохих нэр томьёо байвч, олонх нь хэрэгтэй зүйлүүд болох тул хүчингүй болговоос болохгүй нь илэрхий баймуй. Эл учраас дээр нэр дурдсан 4 ангийн бичиг зохиолыг хүчинтэй хэвээр үлдээж, бага сага засах залруулах өөрчлөх зүйлүүдийг Шинжлэх ухааны хүрээлэнгийн Дуун ухааны тасгаас нэн даруй залруулан гүйцэтгэхийг даалгаваас зохимуй” хэмээн бичжээ.

Энэхүү акт бичгийн *долоодугаар зүйлд* “Хувьсгалын эсэргүү Цэвээн Жамсрангийн эмхэтгэв” хэмээсэн “Бага ястны уг гарлын бичиг”, “Шагжийн хураамжлав” хэмээсэн “Монгол үсгийн дүрмийн толь” энэ хоёр бичиг болбоос, хэдийгээр эсэргүү этгээд нарын гараар түүвэрлүүлэн эмхэтгүүлсэн боловч, уг зохиолууд уулаас тэдний санаа бодлогоор хорлох үүргийн дотор бүтээгдсэн бичгүүд бус [Шинжлэх

ухааны] хүрээлэнгээс тушааж хийлгээд, хянаж хэвлүүлсэн зүйлүүд болмуй. Гэвч тэдний шургуулан оруулсан бага сага үл бүтэх зүйлүүд буй. Үүнийг шүүрдэн арилгаж цэвэр болгохыг Дуун ухаан ба Түүхийн тасагт даалгаж, ерөнхийд [нь] хүчинтэй хэвээр үлдээсүгэй” хэмээн туурвиж үйлдсэн хүнийг нь элдвээр өөлөн буруутгасан ч гэсэн, хийж хэвлүүлсэн судалгааны бүтээлийг нь ямар ч байсан бүрэн үгүйсгэсэнгүй авч үлдээсэн байдаг. Тухайлбал, “Шагжийн хураамжлав” хэмээн хэвлүүлсэн “Монгол үсгийн дүрмийн толь бичиг”-ээс “шүүрдэн арилгаж, цэвэр болгосон” зүйл нь чухам байв гэдгийг сонирхон үзвэл, “Шагж” гэсэн зохиогчийн нэр орсон “*Энэхүү Монгол үсгийн дүрмийн толь бичийг зохиох ажлыг тус хүрээлэнгийн гишүүн Шагжид даалгаснаар түүнийг бие хичээн оролдож*” хэмээсэн 17 үг бүхий хэсгийг нь хусаж арилгасан явдал болно. Зохиогчийн нэр бүхий хэсгийг нь ийнхүү ихээхэн болхи аргаар хусаж арилгасан хэдий ч Шагж гэлэн бичиж туурвисан энэхүү гайхамшигтай бүтээл өнө мөнхөд олон улсын монгол судлаачдын өргөн хэрэглээний ширээний ном байна гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Академич Ж.Болдбаатар 2017 онд бичиж хэвлүүлсэн “Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт, түүний хор уршиг, үр дагавар” судалгааны бүтээлдээ дүгнэсэнчлэн “Аливаа хувьсгалт эргэлт, нийгмийн хямрал, давалгааны үед “муу эр дайнд хөөрөв” гэгчийн үлгэрээр улс төрийн хийрхэл дэгдэх нь ёс мэт. Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийн үед ч “ардын дайсан”-ы ул мөрийг оргүй арилгах гэсэн хийрхэл дэгджээ. 1937 оны 9 сарын 15-нд хуралдсан Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурал “ардын дайснууд”-ын ном бүтээлүүдийг “шүүрдэн бүртгэж, хураан авах ба цаашид хэрэглэгдэх улс төрийн дэвтэр зохиох” ажлыг хариуцсан комисс байгуулжээ. Энэ комиссын шийдвэрээр 1920, 1930-аад онд хэвлэгдсэн ном, товхимол, сэтгүүлийн бүртгэлийг нэг бүрчлэн гаргуулж, улс төрийн хэргээр баривчлагдсан, шийтгэгдсэн хүмүүсийн бичиж туурвисан ном, товхимлыг шатаах, хураах, түүнчлэн эмхэтгэл сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллийг хайчлан авч устгах, эсвэл нэр зургийг нь баллах, сохлох зэргээр авирлажээ. Юуны өмнө О.Жамьян, Ж.Цэвээн, С.Шагж, Эрдэнэбатхаан, Ч.Дашням, С.Буяннэмэх, Б.Ринчен, Х.Пэрлээ, Ч.Бат-Очир, Б.Дугаржав, Б.Ишдорж, Ц.Дамдинсүрэн, Д.Чимэд нарын зэрэг монголын шинэ төрж бүрэлдсэн сэхээтний шилдэг төлөөлөгчдийн зохиосон, орчуулсан, нэр дурдагдсан 140 номын нэг хэсгийг нь устгаж, заримыг нь хураах шийдвэр гаргасан” [Болдбаатар 2017. С. 43] байдгийг дурдалтай.

Монгол улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс 2003 онд эрхлэн нийтлүүлсэн “Монгол улсын түүх”-ийн V ботид бичиж тэмдэглэснээр “...1937 оны намраас 1940 он хүртэлх хугацаанд Дотоод явдлын яамнаас зохион байгуулсан хилс хэрэг гэгчид 30000 шахам хүнийг хамруулж, 20000 гаруй хүнийг цаазаар авч, 5700 гаруй хүнийг янз бүрийн хугацаагаар хорих ял ногдуулж” [Монгол 2003. С. 209] байжээ.

Аймшигтай энэхүү “хилс хэрэг”-ээр тухайн үеийн Шинжлэх ухааны хүрээлэнгийн нийгмийн ухааны чиглэлийн олон судлаач улс төрийн талаар шийтгэгдэж, зарим эрдэмтдийн хийж бүтээсэн эрдэм шинжилгээний туурвил бүтээл нь хэлмэгдэж байсныг дотоод, гадаадын монголч эрдэмтэд андахгүй мэднэ. Улс төрийн шинжлэх ухааны тайлбар толь бичгүүдэд “хэлмэгдүүлэлт” гэдэг нэр томъёог тухайн үеийн төрөөс хууль бусаар хийж байсан залхаан цээрлүүлэх ажиллагаа хэмээн тодорхойлжээ.

Ном зүй

Болдбаатар 2017: *Болдбаатар Ж.* Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт, түүний хор уршиг, үр дагавар. УБ., 2017. 64 х

Монгол 2003: Монгол улсын түүх, V боть (XX зуун) [редактор Ж.Болдбаатар, М.Санждорж, Б.Ширэндэв]. УБ., 2003. 501 х

Монгол улс 2020: Монгол улсын Үндэсний номын сангийн баримтын эмхэтгэл, I боть (1921-1971) [эмхэтгэж, хэвлэлд бэлтгэсэн Х.Түмэнбаяр, Д.Мөнхгэрэл, Б.Сарандэлгэр, Ц.Мөнх, Ч.Гансүх, Д.Энхбаяр]. УБ., 2020. 616 х

Пүрэвжав 2020: *Э.Пүрэвжав.* Монгол хэлний хэм хэмжээ судлал. УБ., 2020. 264 х